



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2021 ОНД ХЭРЭГЖИЖ ДУУСАХААР
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 45 ХУВЬ НЬ БҮРЭН
ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2022/01-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	
	Утас: 70363040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер	Б.Батмөнх
2022 он	Утас: 70363036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор	С.Баасансүрэн
	Утас: 70363036	Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Аудитор Ж.Цогт	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
	Аудитор Б.Наранцэцэг	Цахим хаяг: Narantsetsegb@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
Дүрслэлийн товъёг	3-4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	5
Нэгдүгээр бүлэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй хэдий ч төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж байна.	6
1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлоготой уялдуулан төлөвлөөгүй байна.	6
1.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх нь зайлшгүй, тогтолцооны хувьд үр дүнтэй хэдий ч бүрэн хэрэгжүүлдэггүй зөрчил он дамжин гарсаар байна.	7-8
1.3 Аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналын дөнгөж 8,6 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна.	9-10
1.4 “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг” болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гишүүд бүрэн гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.	10-12
Хоёрдугаар бүлэг: 2021 онд хэрэгжиж дуусах төсөл, арга хэмжээний 45.0 хувь нь гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй байна.	12
2.1 Захиалагчийн зүгээс гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.	12-14
2.2 Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын албаны зүгээс УТХО-ын үйл ажиллагаанд үр нөлөө бүхий хяналт шалгалт огт хийгдээгүй байна.	14-16
2.3 Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд гэрээт хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй 2020 оны 3 төсөл арга хэмжээний 228.9 сая төгрөг, 2021 оны 9 төсөл, арга хэмжээний 3,828.1 сая төгрөг зэрэг нийт 4,057.0 сая төгрөг байршуулсан байна.	16-19
Илрүүлсэн зөрчил	19
Дүгнэлт	19-20
Зөвлөмж	20-21
Ирүүлсэн санал, тайлбар	22
Төрийн аудитын газрын тайлбар	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГ	Боловсролын газар
БХБ	Барилга, хот байгуулалт
БШУ	Боловсрол, шинжлэх ухаан
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Техникийн нөхцөлийг бүрэн аваагүй төсөл, арга хэмжээ	7
Хүснэгт 2	Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас төсөвт тусгаагдаж, батлагдсан төсөл, арга хэмжээ	9
Хүснэгт 3	Санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тохируулан хуваарилаагүй төсөл, арга хэмжээ	10

Дүрслэлийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2021 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээний шинж чанарын ангилал	9

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх, ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийг аймгийн ТЕЗ, ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнууд, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны болон санхүүжилтийн баримт материалуудыг хамруулав.

Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд заасан арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан аймаг, сумдын ЗДТГ, аймгийн ОНӨГ, ГХБХБГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, худалдан авалт, санхүүжилттэй холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон улсын төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэх, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.Үүнд: • Төсвийн тухай хууль, • 2021 оны төсвийн тухай хууль, • 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Барилгын тухай хууль, • Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт, • Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр • УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”,

	• Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг хөгжүүлэх 2021 оны жилийн төлөвлөгөө”, • Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжүүд, • Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт, Б.Наранцэцэг нар 2021 оны 3 дугаар сарын 10-аас 4 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Ерөнхий мэдээлэл:	2021 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт ЗГХЭГ болон 3 яаманд харьяалагдах нийт 16,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Аймгийн Засаг даргад 2021 оны УТХО-аар өмнөх оноос шилжиж ирсэн нийт 9,825.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14, шинээр эхлэх нийт 9,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 зэрэг нийт 19,125.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн бөгөөд шинээр эхлэх төсөл, арга хэмжээнд нийт 9,043.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Захиалагч аймгийн ЗДТГ нь өмнөх оноос он дамжин хэрэгжих 14, шинээр эхлэх 6 / <i>шинээр эхлэх 10 төсөл, арга хэмжээнээс 3 нь 2022 онд, 1 нь 2023 онд дуусахаар төлөвлөж, гэрээ байгуулсан.</i> / зэрэг нийт 20 төсөл, арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 11,825.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн бол 7,299.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.

Бүлэг 1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу?

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй хэдий ч төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж байна.

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу?

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлоготой уялдуулан төлөвлөөгүй байна.

1.1.1 2021 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт ЗГХЭГ болон 3 яаманд харьяалагдах нийт 16,300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас аймгийн Засаг даргад нийт 9,300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав./

1.1.2 Дээрх 10 төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол” болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй байна.

1.1.3 Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хөдөө аж ахуй, биотехнологийн их сургуулийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Сэлэнгэ, Сүхбаатар сум/”, 1,100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ ” гэсэн 2 төсөл, арга хэмжээ тусгагдсан бол бусад нь тусгагдаагүй байна.

1.1.4 Өөрөөр хэлбэл УТХО-оор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн төлөвлөөгүй байна.

1.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна уу?

Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх нь зайлшгүй, тогтолцооны хувьд үр дүнтэй хэдий ч бүрэн хэрэгжүүлдэггүй зөрчил он дамжин гарсаар байна.

1.2.1 2021 онд УТХО-ын төлөвлөгөөнд шинээр хэрэгжихээр тусгагдаж, Сэлэнгэ аймгийн Засаг даргад эрх шилжсэн 9,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээнээс 373.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Шаамар сум/ төсөл, арга хэмжээний архитектур төлөвлөлтийн болон зураг төслийн даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.4¹, 3.5² дахь заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав./

1.2.2 Шинээр эхлэх барилга байгууламжийн техникийн нөхцөлийг эрх бүхий байгууллагаас бүрэн аваагүй / дулаан, ус хангамж, холбоо дохиоллын техникийн нөхцөлийг аваагүй / нийт 2,550.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж, батлуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.2³ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 Техникийн нөхцөлийг бүрэн аваагүй төсөл, арга хэмжээ /сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Газрын зөвшөөрөл олгосон огноо	Техникийн нөхцөл олгосон огноо			
			Эхлэх	Дуусах			Цахилгаан хангамж	Дулаан хангамж	Ус хангамж, ариутгах татуурга	Холбоо дохиолол
1	XIII.1.1.210	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Түшиг сум/	2021	2021	550.0	2012.04.24	2020.03.06			
2	XVII.1.20	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Сэлэнгэ, Баянгол сум/	2021	2023	2,000.0	2021.03.23	2022.01.31			
Нийт дүн					2,550.0					

1.2.3 Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнээс зураг, төсөв нь урьдчилан хийгдсэн байх шаардлагатай барилга байгууламж, их засварын нийт 6,550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээний / Хөдөө аж ахуй, био технологийн их сургуулийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ , түлхүүр гардуулах нөхцөлтэй Залуучуудын хөгжлийн ордон /Сэлэнгэ, Сайхан сум/ , Биологийн лаборатори /Сэлэнгэ, Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар сум/ гэсэн 3 төсөл

¹ Архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектур батална.

² Захиалагч барилга байгууламжийн байршилыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

³ Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй. Үүнд: 7.2.1.эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх.

арга хэмжээ хасагдаад / зураг, төсвийг гүйцэтгэгч байгууллагуудтай 273.9 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

1.2.4 Эдгээрээс 550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлахаас өмнө хийсэн бол 6,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсанаас хойш батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4⁴ дахь, Барилгын тухай хуулийн 24.1.1⁵ дэх, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.2⁶ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав./

1.2.5 Захиалагч аймгийн ЗДТГ нь эрх шилжүүлсэн, магадлал хийлгэвэл зохих барилга байгууламж, их засварын нийт 6,550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний зураг төсөвт Барилгын тухай хуулийн 25.2⁷, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын 6.3⁸-т заасны дагуу магадлал хийлгэж, баталгаажуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав.

1.2.6 Барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах, түүнд магадлал хийх нь зайлшгүй, тогтолцооны хувьд үр дүнтэй хэдий ч хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө бүрэн хэрэгжүүлдэггүй зөрчил он дамжин гарсаар байна.

1.2.7 Магадлалын ажлын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг холбогдох хууль, эрхийн актуудад тодорхой тусгаагүй, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт багтаан тооцогддоггүй байна.

1.2.8 Иймээс захиалагч аймгийн ЗДТГ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөвт магадлал хийх зардлыг гэрээнд тусгаагүй ч зураг төсөв зохиогч аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлж байна.

1.2.9 Энэ нь зураг төсөвт магадлал хийлгэх хугацаа, улмаар хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн ажлын явц удаашрах, гүйцэтгэлийн чанарт муугаар нөлөөлөх, гэрээний хугацаанд гүйцэтгэх боломжгүй болох зэрэг эрсдэлийг дагуулж байна.

1.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулсан уу?

Аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналын дөнгөж 8,6 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна.

⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁵ Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 24.1.1.батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх.

⁶ Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй. Үүнд: 7.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх.

⁷ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

⁸ Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд заавал магадлал хийнэ.

1.3.1 Аймгийн ТЕЗ буюу Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 28.2⁹-т заасны дагуу УТХО-ын 2021 оны төлөвлөгөөнд тусгуулахаар ЗГХЭГ болон БШУЯ, БХБЯ, ЗТХЯ, СЯ-дад нийт 31,561.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 46 төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлснээс 7,800.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:


Хүснэгт №2. Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас төсөвт тусгагдаж, батлагдсан төсөл, арга хэмжээ /сая төгрөгөөр/

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Аймгийн ТЕЗ-аас санал хүргүүлсэн, төсөл, арга хэмжээ		Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас тусгагдаж, батлагдсан		2021 онд хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн нийт төсөл, арга хэмжээ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	4	7,100.0	1	7,000.0		
2	Соёлын сайд	8	1,167.4				
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	20	12,122.4	3	800.0	3	800.0
4	Барилга, хот байгуулалтын сайд	9	8,500.0				
5	Зам тээвэр хөгжлийн сайд	5	2,671.2				
Нийт		46	31,561.0	4	7,800.0	3	800.0

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-аас яамдад хүргүүлсэн санал, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль

1.3.2 Дээрх хүснэгтээс харахад аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналын дөнгөж 8,6 хувь нь л улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна.

1.3.3 УТХО-ын төлөвлөгөөнд 2021 онд шинээр хэрэгжихээр батлагдаж, аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн нийт 9,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээ нь шинж чанарын хувьд ТЭЗҮ, зураг төсөв хийлгэх буюу зөвлөх үйлчилгээ 1, тоног төхөөрөмж 1, их засвар 3, барилга байгууламж 5 байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:



⁹ Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

1.3.4 Зураг төслийн даалгаврыг боловсруулаагүй, техникийн нөхцөл бүрэн олгогдоогүй, зураг төсөв нь урьдчилан хийгдээгүй зэргээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулж, батлуулсан талаар тайлангийн 1.2 дугаар бүлэгт тодорхой дурдсан болно.

1.3.5 УТХО-аар Сэлэнгэ аймагт 2021-2023 он дамжин хэрэгжихээр 4,300.0 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл арга хэмжээг төлөвлөж, санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилаагүйгээс 2021 оны санхүүжилтийг 850.0 сая төгрөгөөр дутуу төлөвлөж, баталсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.3.5¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3. Санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тохируулан хуваарилаагүй төсөл, арга хэмжээ /сая төгрөгөөр/

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Батлагдсан		Төсвийн тухай хуулиар 2021 онд хуваарилбал зохих санхүүжилт	Зөрүү
			Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн		
1	Х.1.1.1.7	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2021	2022	2,200.0	500.0	1,100.0	600.0
2	Х.1.1.1.15	Залуучуудын хөгжлийн ордны барилга /Сэлэнгэ, Сайхан сум/	2021	2022	1,100.0	400.0	550.0	150.0
3	Х.4.1.1.12	Ахмадын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	2021	2022	1,000.0	400.0	500.0	100.0
Нийт дүн					4,300.0	1,300.0	2,150.0	850.0

1.3.6 Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй, техникийн нөхцөлийг бүрэн аваагүй, орон нутгийн удирдлагуудаас санал хүргүүлээгүй төсөл арга хэмжээнүүдийг тухайн жилийн УТХО-ын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж буй дээрх байдлуудаас үндэслэн төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг бүрэн хангаж чадахгүй байна гэж дүгнэж байна.

1.4 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?

“Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг” болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гишүүд бүрэн гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

1.4.1 УТХО-ын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-

¹⁰ ... хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана: 29.3.5 шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

ын 2.13¹¹-т заасны дагуу холбогдох албан тушаалтанд шилжүүлэхээр зохицуулагдсан бөгөөд 2021 оны Төсвийн тухай хуулиар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан байна.

1.4.2 УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний эрхийг 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн дотор шилжүүлэх ёстой атал ХХААХҮ, ХНХ, БШУ-ны сайд нар 10 төсөл, арга хэмжээний эрхийг 2 дугаар сард буюу 27-41 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./* Үүнд:

- ХХААХҮ-ийн сайд 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А-33 дугаар тушаалаар 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний,
- ХНХ-ын сайд 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/18 дугаар тушаалаар 4,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний,
- БШУ-ны сайд 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/60 дугаар тушаалаар 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна.

1.4.3 Тайлант онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний эрхийг журамд заасан хугацаанаас хоцроон шилжүүлж байгаа нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах болон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа багасах, улмаар гүйцэтгэл нь чанарын шаардлага хангахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.4.4 Аймгийн ТЕЗ нь эрх шилжсэн, шинээр эхлэх 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар, 10 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./*

1.4.5 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.1¹²-д заасны дагуу захиалагч аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар “Үнэлгээний хороо”-г тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

1.4.6 Дээрх томилогдсон 50 гишүүн / давхардсан тоогоор / -ээс 22 нь “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-ийг мэдүүлээгүй бол 6 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байна. Эдгээр нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1¹³ заалт болон Сангийн сайдын 2015 оны 330 дугаар тушаалыг зөрчсөн байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./*

1.4.8 Хэдийгээр захиалагч аймгийн ЗДТГ нь төлөвлөсөн хугацаанд “Үнэлгээний хороо”-г байгуулж, худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд цахим хэлбэрээр зарласан боловч оролцогч санал ирүүлээгүйгээс шалтгаалж 5 төсөл,

¹¹ Захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх.

¹² Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

¹³ Энэ хуулийн 23.8-д заасан журмын дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

арга хэмжээний НТШ-ийг 2-3 удаа зарлаж, тендерт 60-122 хоног зарцуулснаас “Ажил гүйцэтгэх гэрээ”-г оройтож байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./

1.4.9 Тайлант онд 1 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын дагуу 2 удаагийн тендер шалгаруулалтад тус бүр 8 оролцогч оролцсон бол 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар зохион байгуулсан 1-3 удаагийн тендер шалгаруулалтад 1-19 оролцогч оролцсон байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./

1.4.10 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу 2021 оны бүх худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд оруулсан байна.

1.4.11 Аймгийн ОНӨГ нь тайлант онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1¹⁴-д заасны дагуу тайлагнаж, хагас болон жилийн эцсийн тайланг Сангийн яаманд цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

1.4.12 Захиалагч аймгийн ЗДТГ нь өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй байх үндсэн зарчмын дагуу төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.

Бүлэг 2

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

2021 онд хэрэгжиж дуусах төсөл, арга хэмжээний 45.0 хувь нь гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй байна.

2.1 Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах ажлыг зохион байгуулсан уу?

Захиалагчийн зүгээс гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

2.1.1 Засгийн газрын 2020 оны 21 дүгээр тогтоолоор эрх нь шилжиж ирсэн он дамжин хэрэгжих 9,825.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл, арга хэмжээнээс гадна 2021 оны 15 дугаар тогтоолоор 2021 онд шинээр эхлэх 9,300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг Сэлэнгэ аймгийн Засаг даргад шилжүүлсэн бөгөөд шинээр эхлэх төсөл, арга хэмжээнд нийт 9,043.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

2.1.2 Өмнөх оноос он дамжин хэрэгжих 14, шинээр эхлэх 6 / шинээр эхлэх 10 төсөл, арга хэмжээнээс 3 нь 2022 онд, 1 нь 2023 онд дуусахаар төлөвлөж, гэрээ байгуулсан./

¹⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах хугацаанд ирүүлнэ. 3.1.1. Хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор, 3.1.2. Бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор.

зэрэг нийт 20 төсөл, арга хэмжээг 2021 онд бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 55.0 хувь буюу 11,825.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна. / Судалгаа 3-т дэлгэрэнгүй харуулав /

2.1.3 2021 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 20 төсөл, арга хэмжээний 18 нь барилга байгууламж, их засвар, 1 нь ТЭЗҮ, зураг төсөв хийлгэх зөвлөх үйлчилгээ, 1 нь ерөнхий боловсролын 4 сургуульд биологийн лаборатори байгуулах ажил байна.

2.1.4 450.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Биологийн лаборатори /Сэлэнгэ, Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар сум/” төсөл, арга хэмжээний хүрээнд 4 сумын ерөнхий боловсролын сургуулиудад тендерийн баримт бичигт заагдсан техникийн тодорхойлолтын дагуу 82 төрлийн биологийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, багаж, хэрэгслийг бүрэн нийлүүлж, захиалагч аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй комиссын актаар хүлээн авсан байна.

2.1.5 2021 онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан боловч тодорхой шалтгаануудын улмаас нийт 7,299.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 9 төсөл арга хэмжээ / Судалгаа 3-т дэлгэрэнгүй харуулав/ бүрэн хэрэгжээгүй байна.

Үүнд: **1. 2020 оноос он дамжин хэрэгжсэн:**

- 284.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар /Сэлэнгэ, Жавхлант сум/” төсөл, арга хэмжээ нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг аваагүй, зураг, төсвийг магадлалаар баталгаажуулаагүйгээс хугацаа алдсан,
- 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Халуун усны барилга /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон / гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй,
- 344.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хяраан голын гүүр /Сэлэнгэ, Алтанбулаг сум, 3 дугаар баг/ голын усны түвшин тооцоологдсон хэмжээнээс эрс нэмэгдсэн,
- 441.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 3 дугаар цэцэрлэг, “А” байр / нь гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс,
- 430.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн эзэмшлийн байруудын инженерийн шугам сүлжээний засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон баг, 1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12,13 дугаар байр / гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй,
- 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхэд, залуучуудын парк /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ төсөл, арга хэмжээний инженер геологийн болон гидрогеологийн дүгнэлт, зураг төсөв нь магадлалаар баталгаажсан боловч байршлыг өөрчилснөөс дахин төлөвлөх шаардлагатай болсон,
- 2,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Ерөө сум/ төсөл, арга хэмжээний тендерийн хэмнэлтээр худаг гаргах, бохирын цэвэрлэх байгууламжийн нэмэлт ажил хийх болсон,

2. 2021 онд шинээр эхэлсэн:

- 550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Түшиг сум / төсөл, арга хэмжээ нь төвлөрсөн халаалт муугаас шалтгаалж сантехникийн болон дотор засал чимэглэлийн ажил хийгдэх боломжгүй болсон,
- 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөдөө аж ахуй, биотехнологийн их сургуулийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Сэлэнгэ, Сүхбаатар сум/

төсөл, арга хэмжээний судалгааны ажлын явцад суралцагсдын эрэлт өндөр байгаагаас барилга барих газрын хэмжээг томсгох, улмаар дахин төлөвлөх, зураг, төсвийн өөрчлөлт хийх болсон зэргээс шалтгаалж хэрэгжээгүй байна.

2.1.4 Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл аваагүй, газрын инженер-геологийн дүгнэлтийг үнэн зөв хийгээгүй зэргээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлдэг байдлаас гадна Ковид 19 цар тахалтай холбогдож улсын хил хааснаас материалын үнэ огцом нэмэгдсэн, хөл хорио тогтоосон зэрэг шалтгаануудын улмаас гэрээт ажлууд тогтоосон хугацаанд ашиглалтад ороогүй байна.

2.1.5 Хэдийгээр дээрх нөхцөл шалтгаануудын улмаас гэрээт ажлууд тогтоосон хугацаанд бүрэн ашиглалтад ороогүй ч захиалагчийн зүгээс гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй буюу захиалагчийн оролцоо хангалтгүй байна.

2.1.6 Цэвэр усны худаг гаргах, бохирын шугам хийх зайлшгүй шаардлага гарсан гэх үндэслэлээр “Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Ерөө сум/” төсөл, арга хэмжээний тендерийн хэмнэлт болох 171.7 сая төгрөгийг зарцуулах нэмэлт гэрээ байгуулсан боловч нэмэлтээр хийгдэх ажлын зураг, төсвийг магадлалаар баталгаажуулаагүй байна.

2.1.7 Гэрээт хугацаанд хэрэгжиж дуусаагүй 9 төсөл, арга хэмжээнээс 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхэд, залуучуудын парк /Сэлэнгэ, Сүхбаатар сум/” төсөл, арга хэмжээний хугацааг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгасан бол бусад 5,799.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгаагүй байна.

2.1.8 Захиалагч аймгийн ЗДТГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад оруулсны дараа эцсийн санхүүжилтийг олгож, гэрээний биелэлт, үр дүнг үнэлж “Гэрээ дүгнэсэн маягт”-аар баталгаажуулсан байна.

2.2 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү ?

Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын албаны зүгээс УТХО-ын үйл ажиллагаанд үр нөлөө бүхий хяналт шалгалт огт хийгдээгүй байна.

2.2.1 Өмнөх оноос шилжин ирсэн 14, тайлант онд шинээр эхэлсэн 8 зэрэг / зөвлөх үйлчилгээний , тоног төхөөрөмж нийлүүлэх 2 төсөл арга хэмжээ хасагдсан / 2021 онд хэрэгжсэн нийт 22 барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37.1.4¹⁵, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор

¹⁵ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.12¹⁶-т заасны дагуу байгуулсан гэрээний үндсэн дээр аймгийн ГХБХБГ-аар захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлсэн байна.

2.2.2 Тус газрын Барилгын хэлтсийн дарга, инженерүүд нь Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.9¹⁷, 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2¹⁸-т заасны дагуу үе шат бүрд хяналт хийж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, улсын комиссын дарга, гишүүнээр ажиллаж, хяналтын тайлангаар баталгаажуулсан байна.

2.2.3 Барилгын тухай хуулийн 37.1.5¹⁹, “Барилга захиалагчийн дүрэм”-3.1.4²⁰-т заасны дагуу дээрх 10 төсөл, арга хэмжээнд зураг, төсөв зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч компаниудаар гүйцэтгүүлсэн байна. Зураг, төсөв зохиогчийн хяналтыг БХБ-ын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2.3²¹, Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.3²²-т заасны дагуу төсөл, арга хэмжээний үе шат бүрд хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгуулан, зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлтээр баталгаажуулсан байна.

2.2.4 Явцын хяналт хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан боловч гэрээт хугацаанд ашиглалтад оруулаагүй 8 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг тус бүр 73.3-88.4 хувиар үнэлсэн байна.

2.2.5 Барилга байгууламж, их засвараас бусад буюу 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Биологийн лаборатори /Сэлэнгэ, Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар сум/ ” төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтнээр ахлуулсан ажлын хэсэг / Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ОНӨГ, Боловсролын газрын холбогдох мэргэжилтнүүд оролцсон / захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

2.2.6 Захиалагч аймгийн ЗДТГ нь төсөл, арга хэмжээний явцын санхүүжилтийг гэрээнд заасны дагуу гүйцэтгэгчийн хүсэлт, эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан барилгын ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон бол улсын

¹⁶ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

¹⁷ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

¹⁸ Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.

¹⁹ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

²⁰ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

²¹ Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан гүйцэтгэнэ: 3.2.3 барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

²² Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

комиссын актаар ашиглалтад оруулсан 11 төсөл, арга хэмжээ /Тоног төхөөрөмж 1, барилга байгууламж, их засварын 10/ -ний эцсийн санхүүжилтийг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.29²³, 4.1.30²⁴-д заасны дагуу хяналтын хуудас болон “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулсны үндсэн олгосон байна.

2.2.7 Харин гэрээний хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хувийг үндэслэн 73.3-88.4 хувийн, 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хүүхэд залуучуудын парк / Сэлэнгэ, Сүхбаатар сум / ” төсөл, арга хэмжээний ажлын явцаас шалтгаалж гүйцэтгэгчид 15.1 хувийн санхүүжилтийг олгосон байна.

2.2.8 Тайлант онд шинээр хэрэгжиж, гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөдөө аж ахуй, биотехнологийн их сургуулийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв” төсөл, арга хэмжээний урьдчилсан судалгааны ажил хийгдэж дуусаагүй тул гүйцэтгэгчид санхүүжилт олгоогүй байна.

2.2.9 Тайлант онд улсын комиссын актаар ашиглалтад оруулсан 10 төсөл, арга хэмжээ /ЗТХЯ нь 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүдэрийн замаас Ерөө сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.7 км /Сэлэнгэ, Ерөө сум/ төсөл, арга хэмжээний гэрээг байгуулж, санхүүжилтийг олгосон байна./ -ний 3-т нь чанарын баталгааны асуудлыг тусгаагүй бол 7-д нь чанарын баталгааг 5 хувиар тооцож, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулахаар гэрээнд тусгаж, нийт 129.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

2.2.10 Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт шалгалт хийж, хэрэгжилт, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

2.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэр үр дүнтэй байна уу?

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд гэрээт хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй 2020 оны 3 төсөл арга хэмжээний 228.9 сая төгрөг, 2021 оны 9 төсөл, арга хэмжээний 3,828.1 сая төгрөг зэрэг нийт 4,057.0 сая төгрөг байршуулсан байна.

2.3.1 Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар, 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолуудаар УТХО-аар 2020, 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж, гэрээ нь байгуулагдсан боловч Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үлдэгдэл

²³ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу бөглөн баталгаажуулж ирүүлнэ.

²⁴ Төслийн эцсийн санхүүжилтийг ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

санхүүжилтийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд байршуулахаар зохицуулагдсан байна.

2.3.2 2020 онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан боловч гэрээт хугацаандаа бүрэн хэрэгжээгүй 6 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 475.3 сая төгрөгийг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан.

2.3.3 Үүнээс 2021 онд улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан дараах 3 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 246.4 сая төгрөгийг бүрэн олгосон байна. Үүнд:

- 453.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Түнхэл тосгон/”,
- 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Сайхан сум/”,
- 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд тавилга худалдан авах”.

2.3.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс ашиглалтад хүлээлгэн өгөөгүй дараах 3 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 228.9 сая төгрөг нь барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна. Үүнд:

- 257.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон, цэцэрлэг/ төсөл арга хэмжээ, гүйцэтгэгч “Эрдэнэт конструктив” ХХК,
- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум/, гүйцэтгэгч “Оргил таун констракшн” ХХК,
- 199.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг /, гүйцэтгэгч “Оргил таун констракшн” ХХК.

2.3.5 Захиалагчийн зүгээс ажил эрчимжүүлэх арга хэмжээ авч, гэрээт ажлуудыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусган, Улсын комисст хүлээлгэж өгөөгүй тохиолдолд Сангийн яамны “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэх санал хүргүүлж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх тухай “Оргил таун констракшн” ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 02/06, 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 02/641, 8 дугаар сарын 31-ний өдрийн 02/798, “Эрдэнэт конструктив” ХХК-д 2021 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 02/623, 8 дугаар сарын 31-ний өдрийн 02/799 дугаар албан бичгүүдээр хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл ажлыг дуусгаж, улсын комисст хүлээлгэж өгөөгүй байна. Иймээс захиалагч аймгийн ЗДТГ нь дээрх 2 компанийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн бөгөөд “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

2.3.6 Өмнөх онд дээрх 3 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг 49-80 хувиар үнэлж, нийт 366.9 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна. Үүнд:

- 257.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон, цэцэрлэг/ төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг 80 хувиар үнэлж, 188.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон,

- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг 50 хувиар үнэлж, 90.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон,
- 199.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг / төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг 49 хувиар үнэлж, 88.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

2.3.7 Бид аудитын явцад 2020 онд ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан дээрх 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцыг газар дээр нь тулган баталгаажуулахад ажлын гүйцэтгэлийг бодит байдлаас илүү үнэлж, санхүүжилтийг олгосон бөгөөд дээрх байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан нөхцөл байдал ажиглагдаж байлаа.

2.3.8 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум/ төсөл, арга хэмжээний дээврийн засварын ажил эхлэл төдий буюу зураг төсөвт заагдсаны дагуу хийгдээгүй байхад ажлын гүйцэтгэлийг 50.0 хувиар үнэлж, 90.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.3.9 257.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон, цэцэрлэг/ төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг 80 хувиар үнэлж, 188.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон хэдий ч ажлын гүйцэтгэл хангалтгүйгээс цэцэрлэгийн анги бүлгүүдийг нэг хэсэг рүү нь шахаж, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл алдагдсан байна.

2.3.8 2020-2021 онд дамжин хэрэгжих болон 2021 онд шинээр хэрэгжиж тухайн онд ашиглалтад хүлээн өгөхөөр гэрээ байгуулсан боловч ашиглалтад хүлээлгэн өгөөгүй 9 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 3,828.1 сая төгрөгийг Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

2.3.8 Тайлант онд улсын комиссын актаар хүлээн авсан 11 төсөл, арга хэмжээнээс 10 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна.

2.3.9 Харин өмнөх оноос он дамжин хэрэгжсэн 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүдэрийн замаас Ерөө хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.7 км / Сэлэнгэ, Ерөө сум / ” төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх “ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.3.10 Өмнөх аудитаар 11 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмж бүрэн, 3 зөвлөмж дутуу хэрэгжсэн бөгөөд дараах 2 зөвлөмж огт хэрэгжээгүй байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч байх.
- “Үнэлгээний хороо”, “Ажлын хэсэг”-т ажиллах гишүүдийн “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-ийг бүрэн гаргуулж, албан тушаалтнуудын овог, нэр, гарын үсгээр баталгаажуулж, архивлах.

2.3.11 Өмнөх аудитаар өгсөн дээрх 2 зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр алдаа, зөрчлийг давтан гаргасан тул МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **6,550.0** сая төгрөгийн дараах зөрчил илэрч, албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- 373.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Шаамар сум/ төсөл, арга хэмжээний архитектур төлөвлөлтийн болон зураг төслийн даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй,
- Шинээр эхлэх барилга байгууламжийн техникийн нөхцөлийг эрх бүхий байгууллагаас иж бүрэн аваагүй нийт 2,550.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж, батлуулсан,
- Нийт 3,626.2 сая төгрөгийн /*давхардсан дүнг хасаж тооцов*/ төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсанаас хойш батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлоготой уялдуулан төлөвлөөгүй байна.
- Барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах, түүнд магадлал хийх нь зайлшгүй, тогтолцооны хувьд үр дүнтэй хэдий ч бүрэн хэрэгжүүлдэггүй зөрчил он дамжин гарсаар байна.
- Аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналын дөнгөж 8,6 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна.
- УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний эрхийг 27-41 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна.
- “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-ийг мэдүүлээгүй бөгөөд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.
- Захиалагчийн зүгээс гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.
- Он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн дагуу жигд хуваарилаагүй байна.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын албаны зүгээс УТХО-ын үйл ажиллагаанд үр нөлөө бүхий хяналт шалгалт огт хийгдээгүй байна.
- 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүдэрийн замаас Ерөө хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.7 км / Сэлэнгэ, Ерөө сум / ” төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.
- Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд гэрээт хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй 2020 оны 3 төсөл арга хэмжээний 228.9 сая төгрөг, 2021 оны 9 төсөл, арга хэмжээний 3,828.1 сая төгрөг зэрэг нийт 4,057.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг байршуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж- д:

- УТХО-оор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улс, аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хүргүүлж байх.
- УТХО-д газрын зөвшөөрөл болон бусад дүгнэлтүүд нь гарсан, техникийн нөхцөл нь бүрэн олгогдсон, зураг төслийн даалгаврыг боловсруулж, баталгаажуулсан, зураг төсөв нь урьдчилан хийгдсэн зэрэг төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээнүүдийг тусгуулах арга хэмжээ авах.
- 2020-2021 онуудад хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан боловч гэрээт хугацаанд ашиглалтад оруулаагүй төсөл, арга хэмжээний шалтгааныг тодорхойлж, нэн яаралтай ашиглалтад оруулах арга хэмжээ авах.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа-д:

- 2020-2021 онуудад хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан боловч гэрээт хугацаанд ашиглалтад оруулаагүй төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгах, хэрэгжилтийг бүрэн хангуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авч, ашиглагч байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах.
- Үнэлгээний хороонд томилогдсон гишүүдийн “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-ийг бүрэн гаргуулж, гарын үсгээр баталгаажуулах.
- Төсөл арга хэмжээний явцын гүйцэтгэлийг бодитоор тодорхойлсны үндсэн дээр гэрээний дагуу санхүүжилтийг олгож байх.
- Гүйцэтгэгчээс шалтгаалан гэрээт хугацаанд ашиглалтад оруулаагүй төсөл, арга хэмжээнд гэрээний дагуу алданги тооцох.

Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан-д:

- “Үнэлгээний хороо”-нд томилогдсон гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүрэн гаргуулж, гарын үсгээр баталгаажуулж, архивлах.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн


- УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, орон нутгийн өмч хөрөнгийг бүртгэл, тайланд бүрэн тусгаж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

Ж.ЦОГТ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ИРҮҮЛСЭН
САНАЛ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-2223

2022.04.29 № 01/450
танай _____-ны № _____

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ЭНХТУЯА ТАНАА

**Аудитын тайлангийн төсөлд
тайлбар хүргүүлэх тухай**

Тайлант 2021 онд Ковид-19 цар тахалтай холбоотой улсын хил, гаалийн үйл ажиллагааг түр хаасан, улмаар импортын барилгын материалын нийлүүлэлт буурч үнийн өсөлт үүссэн зэрэг нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ихээхэн нөлөө үзүүлсэн.

Иймээс Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/4063, 11 дүгээр сарын 04-ний өдрийн 1/4353 дугаар албан бичгүүдээр болон сургалт, зөвлөгөөнөөр цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлж барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн эдийн засгийн хүндрэлийг даван туулах, чадамжийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор санхүүжилтийг уян хатан шийдвэрлэх, ажлын гүйцэтгэлд нийцүүлж гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх зэргээр дэмжиж ажиллах чиглэл өгсөн.

Түүнчлэн гүйцэтгэгч байгууллага ажил гүйцэтгэж дуусан Улсын комисс ажиллуулах хүсэлт өгснөөс хойш комиссын бүрэлдэхүүн бүрдэж, техникийн болон Улсын комисс ажиллахад хугацаа алддаг тул гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу гэрээний үүргийг биелүүлсэнд тооцож алданги ногдуулаагүй болно. Иймээс "Гүйцэтгэгчид 37.4 сая төгрөгийн алданги ногдуулаагүй байна." Гэсэн зөрчлийг алдаа, зөрчлийн дүнгээс хасаж өгөхийг хүсье.

"Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн", "Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллаж, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Ж.САЙНЦОГ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ӨГСӨН ТАЙЛБАР

Тайлант онд “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор БХБ-ын сайдын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/4063, 11 дүгээр сарын 04-ний өдрийн 1/4353 дугаар албан бичгүүдээр барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн эдийн засгийн хүндрэлийг даван туулах, чадамжийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор санхүүжилтийг уян хатан шийдвэрлэх, гүйцэтгэлийн болон чанарын баталгааг чөлөөлөх зэргээр дэмжиж ажиллах чиглэл өгсөн байна.

Мөн УТХО-ын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч компаниуд ажлаа бүрэн гүйцэтгэсний дараа “Улсын комисс ажиллуулах хүсэлт” өгснөөс хойш комиссын бүрэлдэхүүн бүрдэж, комисс ажиллахад хугацаа шаардагддаг тул гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу гэрээний үүргийг биелүүлсэнд тооцож алданги ногдуулаагүй гэсэн тайлбарыг хүлээн авч 37.4 сая төгрөгийн зөрчлийг албан шаардлагын дүнгээс хасаж тайланд өөрчлөлт орууллаа.